№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв тог	Хэрэгжүүлэх хуваарь 2025 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод үйл ажиллагааны зардал	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Дотоод үйл ажиллагааны зардал	11-р сар	“Улз групп”ХХК-ийн удирдлагууд
3.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	Дотоод үйл ажиллагааны зардал	Сар бүр	“Улз групп”ХХК-ийн удирдлагууд

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020424 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ**

Хүснэгт 7 Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан
1.	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.	9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.
2.		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	11 сарын 1-нд багтаан		
3.		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комиссст хүлээлгэн өгөх.	10-р сараас 12-р сарын 1нд багтаан		

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020424 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 8 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д.д	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1,000,000
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1,700,000
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	300,000
4	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1,500,000
5	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	5,500,000
6	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө	500,000
7	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	16,230,000
8	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын зардал	5,500,000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,230,000
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	33,460,000

Архангай аймгийн байгаль орчны газраас ирсэн 2025.04.01 №72 дугаартай саналын дагуу доорх ажлуудыг нэмж төлөвлөн оруулсан бөгөөд 14,730,000 төгрөгийн зардал нэмсэн, Орон нутгаас ирсэн Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд модыг хашаажуулах ажил нэмж хийгдэх болсонтой холбоотой 4,000,000 төгрөг нийт 33,460,000 төгрөгийн зардалтай болоод байна. Нэмж төлөвлөсөн мөнгөн дүнгээр барьцаа төлбөрөө нэмж байршуулсан болно.

1. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажилдаа ховор ургамал болох Баязагваа (Төвд ланцай) ургамлыг хашиж хамгаалах арга хэмжээг авахаар төлөвлөгөөндөө нэмэлтээр оруулж байна. Хашаажуулах ажлыг компанийн ажилчид өөрсдөө гүйцэтгэх бөгөөд хашаа худалдаж авах зардал болох **3500000** төг төлөвлөн оруулж байна.
2. Биологийн нөхөн сэргэлтийг өөрсдийн хүн хүчээр мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авч хийх бөгөөд нөхөн сэргээлтийн стандартын дагуу номорлөгч болон олон наст малын идэмж сайн ургамлын үрийг тариална. Биологийн нөхөн сэргээлтийн зардалд ургамлын үр худалдаж авах **8230000** төгрөгийн зардлыг нэмж тусгасан болно.
3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө дээр Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийг бүрэн ажилд оруулах ажлын зардалд болох **3000000** төгрөгийг тус тус нэмж төлөвлөн оруулсан.
4. Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд тарих модоо хашаажуулах ажлын зардалд **4000000** төгрөг нэмж төсөвлөн оруулсан.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020424 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025 оны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримтууд



Цахим гүйлгээний баримт

Хүснэгтийн лавлах дугаар: S85480413202504043

Татсан огноо: 2025-04-04 10:01

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145102071 MN510015008145102071	100900013406	14,730,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга MV020442 ТАЛБАЙН 2025 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАРЬЦ	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-04-04	



Цахим гүйлгээний баримт

Хүснэгтийн лавлах дугаар: 310305396

Татсан огноо: 2025-01-06 14:15

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145102071 MN510015008145102071	100900013406	14,730,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга MV020442 талбайн 2025 оны Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-01-06	

Гүйлгээг шинсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
g. mijidsamdan		

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020424 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Цахим гүйлгээний баримт

Хүснэгтийн лавлах дугаар: S10916799202504293

Татсан огноо: 2025-04-29 10:20

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145102071 MN510015008145102071	100900013406	4,000,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГААЛ	Гүйлгээний утга MV-020424 2025 ОНЫ БОНС-Н БАРЬЦЛА,БО НӨХ	Гүйлгээний огноо 2025-04-29
	Хүлээн авагчийн банк Төрийн сан		

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХХК.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020424 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2022 оны 12 дугаар сарын –ны өдрийн
..... дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт


Батлав:
Армико майнинг корпорац ХХК-ийн
захирал Г. Мижидсамдан /


Хүлээн авсан:
АМГТГ-ын Уул уурхайн хэлтсийн
дарга Т.Зууннаст /


**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН
ӨЛИЙН ГОЛ-1 ОРДЫН 2025 ОНЫ
УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Ашигт малтмалын төрөл: Алт (Шороон)
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-020442
Нэмэлт АТЗ-ийн дугаар:



/П.Зоригт/

БОЛОВСРУУЛСАН:

1. Ерөнхий инженер
2. Уулын инженер
3. Баяжуулагч инженер
4. Механик инженер
5. Эдийн засагч

2025 он

Хүснэгтийн лавлах дугаар: S85480413202504043

Татсан огноо: 2025-04-04 10:01


Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145102071 MN510015008145102071	100900013406	14,730,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга MV020442 ТАЛБАЙН 2025 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАРЬЦ	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-04-04	

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

Хүснэгтийн лавлах дугаар: 310305396

Татсан огноо: 2025-01-06 14:15

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145102071 MN510015008145102071	100900013406	14,730,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга MV020442 талбайн 2025 оны Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-01-06	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
g. mijidsamdan		

2025 оны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр шилжүүлсэн баримтууд

Хүснэгтийн лавлах дугаар: S10916799202504293

Татсан огноо: 2025-04-29 10:20

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145102071 MN510015008145102071	100900013406	4,000,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга MV-020442 2025 ОНЫ БОНС-Н БАРЬЦАА, БО НӨХ	Гүйлгээний огноо 2025-04-29
	Хүлээн авагчийн банк Төрийн сан		



Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.



Г

7

Байгаль Орчин Уур Амьсгалын
Өөрчлөлтийн яам-д

“УЛЗ ГРУПП” ХХК

6183506 Улаанбаатар хот, БЗД 6-р хороо,
13-р хороолол, Улз Гол Цогцолбор

Манай 2025-04-29 № 85748

Танай _____-ны №_____ -т

Г

7

Xүсэлт гаргах тухай

Манай компани нь MV-020442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2021 оны 05-р сарын 11-ны өдрийн 0291 дугаар бүхий шүүхийн шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг сэргээсэн.

Тусгай зөвшөөрлийг сэргээнээс хойш ашиглалтын үйл ажиллагаа явуулагүй ба 2024 онд бичиг баримтын бүрдэл, уурхайн бэлтгэл ажил зэргээс хамаарч 2024 оны 08-р сараас үйл ажиллагаа явуулсан.

“УЛЗ ГРУПП” ХХК нь тус яамны төрийн сан дахь 100900013406 тоот Байгаль орчны нөхөн сэргээх баталгаа дансанд байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээлтийн хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгө 2024 оны 05 сарын 03-ны байдлаар 32,450,000 төгрөг, 2025 онд 33,460,000 төгрөг тус тус байршуулж нийт 65,910,000 төгрөг байршуулсан байна.

Иймд манай Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

ЗАХИРАЛ



А.БҮРЭНТОГОХ

**УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСЭД
ОЛБОРЛОЛТ ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ
ТАЛБАЙД ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ, НӨХӨН
СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот

Дугаар УС-02/2025 оны 02 сарын 14 өдөр

Энэхүү гэрээг нэг талаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (цаашид “БОУАЯ” гэх), Ашигт малтмал, газрын тосны газар (цаашид “АМГТГ” гэх), Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Салбарын хяналтын газар (цаашид “АҮЭБЯ-ны СХГ” гэх), Архангай аймгийн Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас **Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутагт орших Өлийн голын алтны шороон орд дахь ашигт малтмалын MV-020442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч **Армико майнинг корпораци** (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам” (цаашид “журам” гэх)-ыг тус тус үндэслэн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмал ашиглахтай холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож байгуулав.**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь **MV-020442** тоот ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд давхацсан хэсэг (цаашид “давхацсан талбай” гэх)-т холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах бөгөөд эвдэрсэн газрыг зохих журмын дагуу нөхөн сэргээж, тухайн талбайг хүлээлгэн өгнө.

1.2. Энэхүү гэрээ байгуулагдсаны дараа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхацсан талбайд холбогдох уулын ажлын төлөвлөгөөг Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлнэ.

1.3. Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2-т заасан давхацсан талбайн хилийн заагийг тогтоож, шав тэмдэг тавьсан акт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Усны тухай хуулийн 22.2-т заасан усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бусийн хилийн заагтай давхцалтай хэсгийг Ашигт малтмалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу буцаан өгөх бөгөөд тухайн бүсэд нөхөн сэргээлтээс бусад үйл ажиллагаа явуулах, усны санг бохирдуулахыг хориглоно.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхацсан талбайд ногдох, тодорхой нөхцөлд хязгаарласан нөөцийн эдийн засгийн үр ашгийг тооцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулснаас хойш **9** сарын дотор Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлнэ.

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхацсан талбайд ногдох, эдийн засгийн үр ашигтай нөөцийг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийг гэрээ байгуулснаас хойш **12** сарын дотор Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ТЭЗҮ батлагдсанаас хойш **9** сарын дотор уурхайг улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлтээ гаргана.

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн удирдлага өөрчлөгдхөх бүрт холбогдох баримтын хуулбарыг Ашигт малтмал, газрын газарт албан бичгээр хүргүүлнэ.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаас өмнө БОУАӨЯ-ны Төрийн сан банк дахь тоот дансанд байршуулна.

2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний хэрэгжилтийн тайланг тухайн жилийн уулын ажлын тайлан хэлбэрээр боловсруулж, дараа оны уулын ажлын төлөвлөгөөний хамтаар жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан болон нөхөн сэргээлтийн тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан БОУАӨЯ-нд хүргүүлнэ.

2.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний бусад оролцогчдын төлөөллийг давхацсан талбайд саадгүй нэвтрүүлнэ.

2.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудаас шаардсан мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгнө.

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын эрх, үүрэг

3.1. Ашигт малтмал, газрын тосны газар нь энэхүү гэрээний хэрэгжилтийн тайлан, мэдээг жил бүрийн 12 дугаар сард багтаан гэрээний бусад оролцогчдоос хүлээн авч, гэрээг сунгах бөгөөд гэрээний үүргийн биелэлт хангалтгуй тохиолдолд холбогдох байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд зохих журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түдгэлзүүлж, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн талаар энэхүү гэрээний 3.1-д заасан хугацаанд холбогдох байгууллагаас санал, дүгнэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг сунгахыг зарчмын хувьд дэмжсэн гэж үзэж, зохих журмын дагуу сунгана.

3.3. Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээг сунгасан эсэх талаарх мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сард багтаан холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.4. Ашигт малтмал, газрын тосны газар нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

4.1. БОУАӨЯ нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.2. БОУАӨЯ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, дүгнэлтээ холбогдох саналын хамт жил бүрийн 12 дугаар сард багтаан Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

4.3. Байгаль орчны улсын байцаагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийн талаарх дүгнэлтээ _____ ажлын өдөрт багтаан Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

**Тав. Салбарын хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны
байгууллагын эрх, үүрэг**

5.1. Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Салбарын хяналтын газар нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2. Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Салбарын хяналтын газар нь иргэдийн өргөдөл, гомдол болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.

5.3. Салбарын хяналтын улсын байцаагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийн талаарх дүгнэлтээ _____ ажлын өдөрт багтаан Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

5.4. Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Салбарын хяналтын газар нь тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн талаарх санал, дүгнэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

Зургаа. Орон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

6.1. Орон нутгийн захиргааны байгууллага нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох хууль тогтоомж болон энэхүү гэрээний хэрэгжилтийн талаар тухайн орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл өгнө.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээ болон орон нутагтай хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл орон нутгийн захиргааны байгууллага нь энэ тухай Ашигт малтмал, газрын тосны газарт албан бичгээр мэдэгдэнэ.

6.3. Орон нутгийн захиргааны байгууллага нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих журмын дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

6.4. Орон нутгийн захиргааны байгууллага нь энэхүү гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг гэрээний оролцогч бусад талуудаас зохих журмын дагуу авах эрхтэй.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд давхацсан талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагааг дуусгавар болгон уурхайг хааж, нөхөн сэргээсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд хүчинтэй байна. Талууд гэрээний биелэлтийг дараа жилийн 1 дүгээр сард багтаан дүгнэнэ.

7.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давагдашгүй хүчин зүйлсийн улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд үүссэн нөхцөл байдлын талаар Ашигт малтмал, газрын тосны газарт албан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

7.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээг дүгнэж, дуусгавар болгох хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Ашигт малтмал, газрын тосны газар холбогдох байгууллагуудын оролцоо бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэнэ.

Найм. Талуудын хүлээх хариуцлага

8.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас түүний ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тэрээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлнэ.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу биелүүлээгүй бол Ашигт малтмал, газрын тосны газар гэрээг дуусгавар болгох бөгөөд энэ тухай гэрээний бусад оролцогчдод албан бичгээр мэдэгдэнэ.

8.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, холбогдох бусад эрх зүйн актыг зөрчсөн бол тухайн зөрчлийг илрүүлсэн этгээд энэхүү гэрээг цуцлах ноцтой үр дагавартайгаас бусад тохиолдолд түүнд зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна.

Ашигт малтмал, газрын тосны газар шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд зохих журмын дагуу ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түдгэлзүүлж болно.

Ес. Маргаан хянан шийдвэрлүүлэх тухай

9.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд харьяаллын дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад зүйл

10.1. Гэрээг монгол хэл дээр ижил хүчинтэй 6 (зургаан) эх хувь үйлдэх бөгөөд гэрээний оролцогч тус бүр 1 (нэг) хувийг хадгална.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

АМГТГ-ын даргын үүргийг тур орлон
гүйцэтгэгч

БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын дарга

Ш.ГАНХУЯГ

АҮЭБЯ-ны СХГ-ын дарга

Архангай аймгийн Засаг дарга

Армико майнинг корпораци ХХК-ийн

гүйцэтгэх захирал



Г.МИЖИДСАМДАН



ГАРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ
ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуддан: info@mrpam.gov.mn,
Цахим хуудас: mrpam.gov.mn

2025. 02. 27 № 11/1030

танай _____ -ны № _____ -т

Г Гэрээний тухай

Танай компанийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/18 дугаартай албан бичгээр ирүүлсэн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших MV-020442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өлийн гол-1 нэртэй алтны шороон ордын талбайд байгуулсан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж, нөхөн сэргээх үйл ажиллагааны УС-02/2025 дугаартай гэрээ, MV-004780 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бодонтын ам нэртэй алтны шороон ордын талбайд байгуулсан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж, нөхөн сэргээх үйл ажиллагааны УС-01/2025 дугаартай гэрээг тус тус хүлээн авлаа.

Иймд “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ”-ээр хүлээсэн үүргийн дагуу холбогдох бичиг баримтын бүрдэл хангаж олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх, шав тэмдгийн бүрэн бүтэн байдлыг хангах, энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалтай талбайд нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэн хүчин төгөлдөр мөрдөж буй шаардлага, стандартад нийцүүлэн, төлөвлөлтийн дагуу чанартай гүйцэтгэх, хариуцлагатай уул уурхайн зарчмыг баримталж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.



1525401748
88107628 info@mrpam.gov.mn

БОАЖЯ, Архангай аймгийн Засаг дарга, АМГТГ, МХЕГ, “Улз групп” ХХК-ийн MV-020442 тоот тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ

**УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСЭД
ОЛБОРЛОЛТ ЯВУУЛЖ ЭХЭЛСЭН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ТАЛБАЙД ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ,
НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар УС- 09/2019

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам (цаашид “БОАЖЯ” гэх), Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Архангай аймгийн Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас Архангай аймгийн Цэнхэр, сумын Орхон багийн нутагт орших “Өлийн гол” нэртэй алтны шороон ордын ашигт малтмалын MV-020442 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Улз групп” ХХК (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам” (цаашид “журам” гэх)-ыг тус тус үндэслэн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмал ашиглахтай холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь MV-020442 тоот тусгай зөвшөөрлөөр олгосон талбайн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд давхацсан хэсэг (цаашид “давхацсан талбай” гэх)-т холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах бөгөөд эвдэрсэн газрыг зохих журмын дагуу нөхөн сэргээж, тухайн талбайг хүлээлгэн өгнө.

1.2. Энэхүү гэрээ байгуулагдсаны дараа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхацсан талбайд холбогдох уулын ажлын төлөвлөгөөг Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлнэ.

1.3. Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 2.4-т заасан давхацсан талбайн хилийн заагийг тогтоож, шав тэмдэг тавьсан акт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

1.4. БОАЖЯ-наас ирүүлсэн усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхцалтай хэсгийн солбицлуудыг хэвлэж энэхүү гэрээнд хавсаргана.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Усны тухай хуулийн 22.2-т заасан усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхцалтай хэсгийг Ашигт

БОАЖЯ, Дорнод аймгийн Засаг дарга, АМГТГ, МХЕГ, “Баяжмал алт” ХХК-ийн MV-03613 тоот тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ малтмалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу буцаан өгөх бөгөөд тухайн бүсэд нөхөн сэргээлтээс бусад үйл ажиллагаа явуулах, усны санг бохирдуулахыг хориглоно.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхацсан талбайд ногдох, тодорхой нөхцөлд хязгаарласан нөөцийн эдийн засгийн үр ашгийг тооцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулснаас хойш **9 сарын дотор Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлнэ.**

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхацсан талбайд ногдох, эдийн засгийн үр ашигтай нөөцийг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийг гэрээ байгуулснаас хойш **12 сарын дотор Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ТЭЗҮ батлагдсанаас хойш **9** сарын дотор уурхайг улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлтээ гаргана.**

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн удирдлага өөрчлөгдөх бүрт холбогдох баримтын хуулбарыг Ашигт малтмал, газрын тосны газарт албан бичгээр хүргүүлнэ.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаас өмнө БОАЖЯ-ны Төрийн сан банк дахь **900013406 тоот дансанд байршуулна.**

2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний хэрэгжилтийн тайланг тухайн жилийн уулын ажлын тайлан хэлбэрээр боловсруулж, дараа оны уулын ажлын төлөвлөгөөний хамтаар жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан болон нөхөн сэргээлтийн тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан БОАЖЯ-нд хүргүүлнэ.

2.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний бусад оролцогчдын төлөөллийг давхацсан талбайд саадгүй нэвтрүүлнэ.

2.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудаас шаардсан мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгнө.

2.11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 1.4-т заасан усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхцалтай хэсэгт олборлолтын үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно. Энэхүү талбайг хамгаалах асуудлыг хариуцах ба олборлолтод өртсөн тохиолдолд хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын эрх, үүрэг

3.1. Ашигт малтмал, газрын тосны газар нь энэхүү гэрээний хэрэгжилтийн тайлан, мэдээг жил бүрийн 12 дугаар сард багтаан гэрээний бусад оролцогчдоос хүлээн авч, гэрээг сунгах бөгөөд гэрээний үүргийн биелэлт хангалтгүй тохиолдолд холбогдох байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд зохих журмын дагуу

БОАЖЯ, Архангай аймгийн Засаг дарга, АМГТГ, МХЕГ, “Улз групп” ХХК-ийн MV-020442 тоот тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түдгэлзүүлж, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн талаар энэхүү гэрээний 3.1-д заасан хугацаанд холбогдох байгууллагаас санал, дүгнэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг сунгахыг зарчмын хувьд дэмжсэн гэж үзэж, зохих журмын дагуу сунгана.

3.3. Ашигт малтмал, газрын тосны газар нь гэрээг сунгасан эсэх талаарх мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сард багтаан холбогдох байгууллагад хүргүүлнэ.

3.4. Ашигт малтмал, газрын тосны газар нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

4.1. БОАЖЯ нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.2. БОАЖЯ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, дүгнэлтээ холбогдох саналын хамт жил бүрийн 12 дугаар сард багтаан Ашигт малтмалын газарт хүргүүлнэ.

4.3. Байгаль орчны улсын байцаагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийн талаарх дүгнэлтээ _____ ажлын өдөрт багтаан Ашигт малтмалын газарт хүргүүлнэ.

Тав. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

5.1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Ашигт малтмалын тухай хуульд зааснаас гадна энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь иргэдийн өргөдөл, гомдол болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.

5.3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийн талаарх дүгнэлтээ **15** ажлын өдөрт багтаан Ашигт малтмалын газарт хүргүүлнэ.

5.4. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээгээр хулээсэн үүргээ хэрхэн биелүүлсэн талаарх санал, дүгнэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан Ашигт малтмалын газарт хүргүүлнэ.

Зургаа. Орон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

6.1. Орон нутгийн захиргааны байгууллага нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох хууль тогтоомж болон энэхүү гэрээний хэрэгжилтийн талаар тухайн орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл өгнө.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээ болон орон нутагтай хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл орон нутгийн захиргааны байгууллага нь энэ тухай Ашигт малтмалын газарт албан бичгээр мэдэгдэнэ.

6.3. Орон нутгийн захиргааны байгууллага нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих журмын дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

6.4. Орон нутгийн захиргааны байгууллага нь энэхүү гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг гэрээний оролцогч бусад талуудаас зохих журмын дагуу авах эрхтэй.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар **ХҮЧИН** төгөлдөр болох бөгөөд давхацсан талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагааг дуусгавар болгон уурхайг хааж, нөхөн сэргээсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд хүчинтэй байна. Талууд гэрээний биелэлтийг дараа жилийн 1 дүгээр сард багтаан дүгнэнэ.

7.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давагдашгүй хүчин зүйлсийн улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд үүссэн нөхцөл байдлын талаар Ашигт малтмалын газарт албан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

7.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээг дүгнэж, дуусгавар болгох хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Ашигт малтмалын газар холбогдох байгууллагуудын оролцоо бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэнэ.

Найм. Талуудын хүлээх хариуцлага

8.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас түүний ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тэрээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлнэ.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу биелүүлэгүй бол Ашигт малтмалын газар гэрээг дуусгавар болгох бөгөөд энэ тухай гэрээний бусад оролцогчдод албан бичгээр мэдэгдэнэ.

8.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, холбогдох бусад эрх зүйн актыг зөрчсөн бол тухайн зөрчлийг ирүүлсэн этгээд энэхүү гэрээг цуцлах ноцтой үр дагавартайгаас бусад тохиолдолд түүнд зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг ханггуулна.


БОАЖЯ, Архангай аймгийн Засаг дарга, АМГТГ, МХЕГ, “Улз групп” ХХК-ийн MV-020442 тоот тусгай зөвшөөрлийн талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ
Ашигт малтмалын газар шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд зохих журмын дагуу ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түдгэлзүүлж болно.

Ес. Маргаан хянан шийдвэрлүүлэх тухай

9.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд харьяаллын дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад зүйл

10.1. Гэрээг монгол хэл дээр ижил хүчинтэй 6 (зургаан) эх хувь үйлдэх бөгөөд гэрээний оролцогч тус бүр 1 (нэг) хувийг хадгална.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@tgram.gov.mn,
Цахим хуудас: tgram.gov.mn

2024. 07. 05 № 11/2933
танай -ны № -т

Гэрээний хугацаа сунгах
тухай

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших MV-020442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өлийн гол-1 нэртэй алтны шороон ордыг эзэмшигч Улз групп ХХК-тай 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж, нөхөн сэргээх үйл ажиллагааны УС-06/2019 дугаартай гэрээ байгуулсан байна.

АМГТГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ байгуулсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтийг үнэлэх, сунгах, дуусгавар болгох ажлын хэсэг гэрээний хэрэгжилтийг хянан хэлэлцээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бүрдээгүй тул 2024 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх шийдвэр гаргасан тул гэрээг сунгасныг үүгээр мэдэгдэж байна.

Мөн ажлын хэсгээс гаргасан дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

- 2024 онд үйл ажиллагаа явуулахдаа энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх,
- Онцгой хамгаалалтын бүсэд эвдэгдсэн талбай болон технологийн замыг нэн даруй нөхөн сэргээх,
- Нөхөн сэргээсэн талбайг орон нутагт актаар хүлээлгэн өгч баталгаажуулах,
- Хамгаалалтын бүсийн шав тэмдгийн бүрэн бүтэн байдлыг хангах, сэргээн засварлах, нотлох баримт үйлдэх,
- Тусгай зөвшөөрлийг бусдад бүхэлдээ шилжүүлсэн бол ЗГ-ын 2015 оны 06 дугаар сарын 08-н өдрийн 235 дугаар тогтоолын 3.3 /Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ журмын хүрээнд талбайгаа бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан өгсөн, эсхүл давхцал бүхий тусгай зөвшөөрөлтэй талбайд гэрээ байгуулсан этгээд талбайг бусдад хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлсэн тохиолдолд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд шилжүүлэн авсан этгээдтэй гэрээг шинэчлэн байгуулна./-т заасны дагуу шилжүүлэн авсан эзэмшигч гэрээг шинэчлэн байгуулах,
- 2024 оны гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ батлагдсан загварын дагуу боловсруулж 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх.



1524404805